



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/101/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага.....	13
4.4 Зөвлөмж.....	13
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28

№

150

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020354

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,294,300.45	73,068,115.59
33	АВЛАГА	5,466,136.00	5,466,136.00
335	Бусад авлага	5,466,136.00	5,466,136.00
3351	Байгууллагаас авах авлага	5,466,136.00	5,466,136.00
35	БАРАА МАТЕРИАЛ	55,828,164.45	67,601,979.59
351	Түүхий эд материал	15,910,508.00	19,931,503.46
35110	Тусгай зориулалттай материал	15,910,508.00	19,931,503.46
354	Хангамжийн материал	39,917,656.45	47,670,476.13
35410	Бичиг хэргийн материал	324,000.00	397,000.00
35420	Аж ахуйн материал	30,778,057.45	31,475,957.13
35440	Түлш, шатах тослох материал	1,680,000.00	1,490,000.00
35450	Барилгын засварын материал	1,680,000.00	1,680,000.00
35460	Хүнсний материал	20,000.00	7,191,920.00
35470	Бусад хангамжийн материал	5,435,599.00	5,435,599.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,201,769,108.81	3,105,702,416.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,201,769,108.81	3,105,702,416.76
392	Биет хөрөнгө	3,164,091,108.81	3,068,024,416.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,098,091,568.50	3,098,091,568.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(84,018,977.41)	(151,347,833.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	117,529,975.00	122,191,327.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,937,244.76)	(73,664,660.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,145,172.99	119,065,172.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,330,714.51)	(65,922,486.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,559,400.00	5,559,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,559,400.00)	(5,559,400.00)
39217	Ном	19,611,329.00	19,611,329.00
393	Биет бус хөрөнгө	37,678,000.00	37,678,000.00
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(220,000.00)	(220,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,678,000.00	37,678,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,263,063,409.26	3,178,770,532.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,263,063,409.26	3,178,770,532.35
51	Засгийн газрын хувь оролцоо	3,263,063,409.26	3,178,770,532.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,544,332.80	254,544,332.80
51101	Өмч: - төрийн	254,544,332.80	254,544,332.80
512	Хуримтлагдсан үр дүн	2,758,587,680.36	2,674,294,803.45
51210	Өмнөх үеийн үр дүн	2,758,587,680.36	2,758,587,680.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(84,292,876.91)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,931,396.10	249,931,396.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,263,063,409.26	3,178,770,532.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,776,475,465.00	897,849,102.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,886,268,113.00	12,718,147.14
120	Нийтлэг татварын бус орлого	2,877,268,113.00	12,718,147.14
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	2,877,268,113.00	7,256,352.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		5,461,795.14
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	9,000,000.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	9,000,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	890,207,352.00	885,130,955.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	845,073,900.00	853,687,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	845,073,900.00	853,687,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,688,952.00	5,193,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,688,952.00	4,524,255.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	669,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,444,500.00	26,249,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,444,500.00	26,249,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	979,976,822.74	982,141,979.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	979,976,822.74	982,141,979.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,166,779.11	951,558,201.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	665,327,983.46	682,284,647.27
210101	Үндсэн цалин	549,830,435.14	567,946,253.04
210104	Урамшуулал	52,822,310.00	49,734,028.00
210105	Гэрээт ажлын хөлс	62,675,238.32	64,604,366.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,955,573.70	93,889,452.86
210201	Тэтгэврийн даатгал	60,695,738.65	67,779,411.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,539,352.38	6,377,067.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,232,076.91	5,564,384.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,301,474.17	1,179,652.69
210205	Эрүүл мэндийн даатгал	13,186,931.59	12,988,937.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,286,961.00	26,341,850.87
210301	Гэрэл, цахилгаан	8,820,961.00	5,948,015.00
210302	Түлш, халаалт	19,155,000.00	18,919,585.87
210303	Цэвэр, бохир ус	1,311,000.00	1,474,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,003,320.00	10,611,215.40
210401	Бичиг хэрэг	1,049,300.00	2,007,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,918,360.00	3,393,615.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,300.00	1,099,700.00
210404	Ном, хэвлэл	2,145,900.00	753,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,452,460.00	2,916,900.00
2105	Нормативт зардал	27,170,435.00	29,763,040.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	837,200.00	1,454,000.00
210502	Хоол, хүнс	26,133,235.00	27,967,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	341,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,463,500.00	829,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	253,500.00	829,300.00
210604	Урсгал засвар	1,210,000.00	
2107	Томилолт, зочны зардал	332,000.00	386,000.00
210702	Дотоод албан томилолт	332,000.00	386,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	451,150.60

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	451,150.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,831,005.95	107,001,544.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	794,500.00	2,353,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,036,505.95	104,648,044.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,810,043.63	30,583,778.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,448,457.00	24,693,990.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,221,905.00	18,416,990.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,676,552.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,550,000.00	6,277,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,954,639.00	101,304.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,564,539.00	98,049.13
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	390,100.00	3,255.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,406,947.63	5,788,483.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,406,947.63	5,788,483.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,796,498,642.26	(84,292,876.91)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,308,594.10	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	163,200.55	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,145,393.55	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,308,594.10)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,795,190,048.16	(84,292,876.91)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	254,544,332.80	249,931,396.10	2,758,587,680.36	0.00	3,263,063,409.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,544,332.80	249,931,396.10	2,758,587,680.36	0.00	3,263,063,409.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,544,332.80	249,931,396.10	2,758,587,680.36	0.00	3,263,063,409.26
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	254,544,332.80	249,931,396.10	2,758,587,680.36	0.00	3,263,063,409.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,544,332.80	249,931,396.10	2,758,587,680.36	0.00	3,263,063,409.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-84,292,876.91	0.00	-84,292,876.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,544,332.80	249,931,396.10	2,674,294,803.45	0.00	3,178,770,532.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	891,600,076.79	885,130,955.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	370,524.79	-
120	Нийтлэг татварын бус орлого	370,524.79	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	370,524.79	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	370,524.79	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	891,229,552.00	885,130,955.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	845,073,900.00	853,687,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	845,073,900.00	853,687,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,711,152.00	5,193,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,711,152.00	4,524,255.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	669,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,444,500.00	26,249,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,444,500.00	26,249,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	891,600,076.79	883,805,955.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,600,076.79	883,805,955.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,790,033.16	853,222,217.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,983,364.47	682,284,647.27
210101	Үндсэн цалин	548,530,917.41	567,946,253.04
210104	Урамшуулал	53,672,725.85	49,734,028.00
210105	Гэрээт ажлын хөлс	64,779,721.21	64,604,366.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,300,192.69	93,889,452.86
210201	Тэтгэврийн даатгал	63,025,904.90	67,779,411.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,422,332.14	6,377,067.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,232,076.91	5,564,384.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,301,474.17	1,179,652.69
210205	Эрүүл мэндийн даатгал	13,318,404.57	12,988,937.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,879,961.00	26,151,850.87
210301	Гэрэл, цахилгаан	8,820,961.00	6,927,600.00
210302	Түлш, халаалт	17,748,000.00	17,750,000.87
210303	Цэвэр, бохир ус	1,311,000.00	1,474,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,883,320.00	9,477,516.00
210401	Бичиг хэрэг	1,049,300.00	2,008,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,918,360.00	3,393,616.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,300.00	1,099,700.00
210404	Ном, хэвлэл	2,145,900.00	753,500.00
210405	Лог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, сэмтгэл	600,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,332,460.00	1,782,700.00
2105	Нормативт зардал	22,813,595.00	37,194,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	837,200.00	1,804,000.00
210502	Хоол, хүнс	21,776,395.00	35,139,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	250,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,253,500.00	959,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	253,500.00	959,300.00
2107	Томилолт, зочны зардал	332,000.00	386,000.00
210702	Дотоод албан томилолт	332,000.00	386,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	796,000.00	451,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	451,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,548,100.00	2,428,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,100.00	2,428,300.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,810,043.63	30,583,738.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,448,457.00	24,693,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,221,905.00	18,416,950.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,676,552.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,550,000.00	6,277,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,954,639.00	101,304.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,564,539.00	98,049.13
213404	Хөрөнгийн	390,100.00	3,255.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,	40,406,947.63	5,788,483.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,406,947.63	5,788,483.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,325,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,325,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,325,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,325,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,325,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,325,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	885,187,300.00	874,050,667.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,187,300.00	874,050,667.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,461,800.00	849,356,717.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,916,200.00	682,284,647.27
210101	Үндсэн цалин	569,349,000.00	567,946,253.04
210104	Урамшуулал	51,567,200.00	49,734,028.00
210105	Гэрээт ажлын хөлс	65,000,000.00	64,604,366.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,664,000.00	93,889,452.86
210201	Тэтгэврийн даатгал	68,381,000.00	67,779,411.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,610,000.00	6,377,067.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,666,000.00	5,564,384.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,365,000.00	1,179,652.69
210205	Эрүүл мэндийн даатгал	13,642,000.00	12,988,937.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,500,000.00	26,151,850.87
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	6,927,600.00
210302	Түлш, халаалт	22,000,000.00	17,750,000.87
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,474,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,017,100.00	6,958,016.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	950,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,603,000.00	2,601,616.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	1,099,700.00
210404	Ном, хэвлэл	84,000.00	84,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	440,000.00	440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,790,100.00	1,782,700.00
2105	Нормативт зардал	37,294,500.00	37,194,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,855,400.00	1,804,000.00
210502	Хоол, хүнс	35,139,100.00	35,139,100.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	250,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	960,000.00	959,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	960,000.00	959,300.00
2107	Томилолт, зочны зардал	450,000.00	290,000.00
210702	Дотоод албан томилолт	450,000.00	290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	460,000.00	451,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	460,000.00	451,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	1,178,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,178,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,725,500.00	24,693,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,725,500.00	24,693,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,425,500.00	18,416,950.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,300,000.00	6,277,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	885,187,300.00	874,050,667.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	853,687,300.00	847,898,816.13
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээссанхүүжих	853,687,300.00	847,898,816.13
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,500,000.00	26,151,850.87
132001	Орон нутгийн төсвөөс	31,500,000.00	26,151,850.87

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,190,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,190,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,190,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,519,500.00
210401	Бичиг хэрэг	1,058,000.00
210402	Тээвэр, шатахуун	792,000.00
210404	Ном, хэвлэл	669,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	96,000.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,325,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,325,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,190,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,190,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,521,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	669,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадал суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 12 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 891.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14,2 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.5 хувиар буюу 84.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь бараа материал, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлттэй холбоотой.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73.0 сая төгрөг болж 7.8 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 83.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 2.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 77.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 67.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,105.7 сая төгрөг болж 288.1 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.3 сая төгрөг, хандив тусламж үнэ төлбөргүйгээр 3.6 сая төгрөгийн хөрөнгө, бусад 3,6 сая төгрөгийн хөрөнгө орлого авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,178.7 сая төгрөг болж 84.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Үр дүнгийн тайлангийн орлого өмнөх оноос 76,2 хувиар буюу 2878,6 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд шинэ хичээлийн барилга ашиглалтанд орсонтой холбоотой буурсантай байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,178.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 925,1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 40,0 сая төгрөгөөр бууруулж, 885,1 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь тайлант онд цар тахлын улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрээр явуулахаар тооцсонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 885.1 сая төгрөгийн төсөв баталснаас 853.6 сая төгрөгийг улсын төсвөөс 31.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 853.6 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 26.2 сая төгрөг нийт 879.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 873.0 сая төгрөгийг зарцуулж 5.8 сая төгрөгийг улсын төсөвт, 0.98 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 873.0 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 3.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.09 сая төгрөгөөр, Хангамж бараа материалын зардал 0.06 сая төгрөгөөр, нормативд зардал 0.10 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 0.008 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 0.0007 сая төгрөгөөр, томилолтын зардал 0.2 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 0.022 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 0.008 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.002 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 0.02 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардал 0.03 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 4.5 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 0.7 сая төгрөг нийт 5.2 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 1.7 сая төгрөг, эд хогшил, багаж техник хэрэгслийн зардалд 0.25 сая төгрөг, томилолтын зардалд 0.096 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 0.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2.3 сая төгрөгийг зарцуулж 0.003 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 879.9 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулахаас 879.9 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулж, хугацаа хоцорсон 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,6 сая төгрөгийн зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоосон. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа эсэхийг шалгах

Тээвэр шатахууны зардлыг шалгах

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг ажлын даалгаврын дагуу бэлтгэсэн, хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0,78 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.06 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 0.36 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0,36 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй хүлээн авсан 0.06 сая төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгэж, залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Сургуулийн сурагчдын үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хүүхдийн тооны ирцтэй тулган баталгаажуулахад 0.3 сая төгрөгөөр илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1./төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ гэсэн заалт-г зөрчсөн байна.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайланд 0.36 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр"-г зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 147 мэдээллээс 139 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба мэдээллээгүй 12, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. 2021 оны 879.9 сая төгрөгийн 26 мэдээллийг ил тод байршуулахаас 649.7 сая төгрөгийн 14 мэдээллийг байршуулж 197.6 сая төгрөгийн 12 мэдээлэл байршуулаагүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-т "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл,

төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Чандмань сумын ерөнхий боловсролын сургууль	3	0.78	1	0.06	1	0.36	1	0.36	-	-
	НИЙТ ДҮН	3	0.78	1	0.06	1	0.36	1	0.36	-	-